



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/148/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цэням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас:88106992 Цахим хаяг: amarjargalp@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал.....	17
5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Р.БОЛОРМАА ТАНАА 7

2021.02.25 № 2/94

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ 7

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Сумын засаг дарга баталж, гүйцэтгэлийн тайланг Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газрын дарга тайлагнасан байна.

Сумын засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтээр 90.2 хувь буюу "А" үнэлгээтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

2021 А4 ТООТ

• 005020076

Аудитын гол асуудал

Эрдэнэцогт сумын Засаг даргын тамгын газар нь Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 57600.0 мянган төгрөгийн үнэ бүхий дизель мотор биетээр байхгүй тооллогоор дутсан байна. Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 дүгээр захирамжаар тус дутагдсан хөрөнгийн эзэн холбогдогчийг тогтоож, хуулийн байгууллагаар шийдвэр гаргуулан байгууллагыг хохиролгүй болгох асуудлыг дарга, нягтлан бодогч нарт үүрэг болгосон ч захирамжийн хэрэгжүүлээгүй байна.

Дээрх Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТӨРГҮҮДЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44929944.00	89914194.00
33	АВЛАГА	18,289.00	28,139,744.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	18,289.00	00.00
335	Бусад авлага	00.00	28,139,744.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	28,139,744.00
35	БАРАА МАТЕРИАЛ	44,911,655.00	61,774,450.00
354	Хангамжийн материал	43,921,655.00	60,784,450.00
35410	Бичиг хэргийн материал	675,500.00	835,500.00
35420	Аж ахуйн материал	43,246,155.00	58,346,155.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	1,602,795.00
35600	Мал амьтад	990,000.00	990,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,261,701,408.84	2,479,057,011.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,261,701,408.84	2,479,057,011.40
392	Биет хөрөнгө	2,233,552,992.02	2,450,648,021.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,240,403,964.69	2,555,230,090.69
39202	Хуримтлагдсан элэгдэл	-174,879,794.36	-234,138,175.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	153,202,800.00	153,202,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-82,498,997.32	-99,486,797.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	192,580,954.00	198,054,954.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-138,424,864.37	-160,400,548.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,915,600.00	49,915,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,746,670.62	-11,729,901.02
393	Биет бус хөрөнгө	28,148,416.82	28,408,989.60
39301	Программ хангамж	250,000.00	552,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-239,583.18	-281,510.40
39303	Бусад биет бус хөрөнгө	28,138,000.00	28,138,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,306,631,352.84	2,568,971,205.40
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	166,847.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	166,847.00
413	Өглөг	00.00	166,847.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	7,247.00
4136	Бусад өглөг	00.00	159,600.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	159,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,306,631,352.84	2,568,804,358.40
51	Засгийн газрын хувь оролцоо	2,306,631,352.84	2,568,804,358.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	494,690,961.00	494,690,961.00
51101	Өмч: - төрийн	494,690,961.00	494,690,961.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,614,791,765.51	1,876,964,771.07
51210	Өмнөх үеийн үр дүн	1,614,791,765.51	1,614,791,765.51
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	262,173,005.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	197,148,626.33	197,148,626.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,306,631,352.84	2,568,971,205.40

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,720,662,529.00	808,832,409.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,335,208,300.00	341,830,576.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,335,208,300.00	341,830,576.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,335,208,300.00	341,830,576.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	633,000.00	2,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,334,575,300.00	339,830,576.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	385,454,229.00	467,001,833.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,906,000.00	24,717,133.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,040,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,906,000.00	14,347,293.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	9,329,840.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	374,518,200.00	442,284,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	374,518,200.00	442,284,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	30,029.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	30,029.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	428,053,313.43	535,013,570.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	428,053,313.43	535,013,570.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	425,448,587.43	505,595,758.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,927,555.00	251,212,351.00
210101	Үндсэн цалин	209,927,555.00	251,212,351.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,805,277.00	31,272,139.00
210201	Тэтгэврийн даатгал	25,805,277.00	21,510,488.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	2,512,123.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	2,009,699.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	476,349.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	4,763,480.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,578,643.00	54,036,829.00
210301	Гэрэл, цахилгаан	4,152,043.00	3,159,829.00
210302	Түлш, халаалт	50,153,600.00	50,770,000.00
210303	Цэвэр, бохир ус	273,000.00	107,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,649,125.00	23,423,050.00
210401	Бичиг хэрэг	3,179,491.00	3,358,980.00
210402	Тээвэр, шатахуун	22,197,576.00	15,202,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,966,633.00	3,949,610.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	273,229.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	774,100.00	852,000.00
210408	Бараа материал акталсны зардал	2,258,096.00	00.00

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативд зардал	6,618,000.00	00.00
210502	Хоол, хүнс	6,618,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,158,700.00	2,291,940.00
210604	Урсгал засвар	4,158,700.00	2,291,940.00
2107	Томилолт, зочны зардал	11,572,050.00	5,986,000.00
210702	Дотоод албан томилолт	7,705,800.00	5,491,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,866,250.00	495,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,354,832.00	20,385,129.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,339,832.00	20,135,015.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	15,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	250,114.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,784,405.43	116,988,320.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,247,250.00	12,387,130.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	45,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,492,155.43	104,601,190.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,604,726.00	29,417,812.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	880,029.00	13,541,756.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	30,029.00	- 00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	13,157,756.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	850,000.00	384,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	304,789.00	15,876,056.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	304,789.00	14,430,350.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,419,908.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,292,609,215.57	273,818,838.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	32,216,076.22	11,645,833.06
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	32,216,076.22	11,645,833.06
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-32,216,076.22	-11,645,833.06
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,260,393,139.35	262,173,005.56

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	386,087,229.00	469,001,833.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	633,000.00	2,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	633,000.00	2,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	633,000.00	2,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	633,000.00	2,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	385,454,229.00	467,001,833.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,906,000.00	24,717,133.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,040,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,906,000.00	14,347,293.00

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	9,329,840.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	374,518,200.00	442,284,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	374,518,200.00	442,284,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	30,029.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	30,029.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	386,087,229.00	469,001,833.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	386,087,229.00	469,001,833.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	383,332,503.00	412,828,277.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,885,275.00	249,588,199.00
210101	Үндсэн цалин	174,893,175.00	217,930,104.92
210102	Нэмэгдэл	29,592,100.00	31,658,094.08
210105	Гэрээт ажлын хөлс	5,400,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,830,124.00	32,870,755.00
210201	Тэтгэврийн даатгал	17,548,124.00	23,276,524.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,070,500.00	2,509,724.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,656,400.00	1,739,281.00
210204	Ажилгүйдлийн даатгал	414,100.00	456,448.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,141,000.00	4,888,778.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,774,541.00	53,765,670.00
210301	Гэрэл, цахилгаан	2,102,700.00	9,410,920.00
210302	Түлш, халаалт	58,488,841.00	44,354,750.00
210303	Цэвэр, бохир ус	183,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,672,400.00	20,602,316.00
210401	Бичиг хэрэг	2,705,371.00	2,725,520.00
210402	Тээвэр, шатахуун	15,060,200.00	13,295,470.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,953,000.00	3,891,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	299,829.00	89,726.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	654,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,615,730.00	1,761,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	00.00
210602	Тавилга	23,200,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,415,730.00	1,761,400.00
2107	Томилолт, зочны зардал	11,622,050.00	7,490,450.00
210702	Дотоод албан томилолт	7,627,300.00	5,491,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,994,750.00	1,999,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,835,131.00	25,583,187.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,732,131.00	25,018,789.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	564,398.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,097,252.00	21,166,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,997,252.00	21,166,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,754,726.00	56,173,556.00

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	1,030,029.00	40,297,500.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	30,029.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	39,297,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	304,789.00	15,876,056.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	304,789.00	14,430,350.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,419,908.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	494,690,961.00	197,148,626.33	1,614,791,765.51	00.00	2,306,631,352.84
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	494,690,961.00	197,148,626.33	1,614,791,765.51	00.00	2,306,631,352.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	494,690,961.00	197,148,626.33	1,614,791,765.51	00.00	2,306,631,352.84
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	262,173,005.56	00.00	262,173,005.56
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	494,690,961.00	197,148,626.33	1,876,964,771.07	00.00	2,568,804,358.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	444,284,700.00	429,854,350.00	14,430,350.00	96.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	444,284,700.00	429,854,350.00	14,430,350.00	96.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	403,405,200.00	389,556,850.00	13,848,350.00	96.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,289,600.00	249,588,199.00	1,701,401.00	99.32
210101	Үндсэн цалин	217,346,400.00	217,930,104.92	-583,704.92	100.27
210102	Нэмэгдэл	33,943,200.00	31,658,094.08	2,285,105.92	93.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,160,900.00	32,870,755.00	1,290,145.00	96.22
210201	Тэтгэврийн даатгал	24,109,300.00	23,276,524.00	832,776.00	96.55

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	2,512,900.00	2,509,724.00	3,176.00	99.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,010,300.00	1,739,281.00	271,019.00	86.52
210204	Ажилгүйдлийн даатгал	502,600.00	456,448.00	46,152.00	90.82
210205	Эрүүл мэндийн даатгал	5,025,800.00	4,888,778.00	137,022.00	97.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,993,000.00	53,765,670.00	5,227,330.00	91.14
210301	Гэрэл, цахилгаан	5,706,000.00	9,410,920.00	-3,704,920.00	164.93
210302	Түлш, халаалт	53,287,000.00	44,354,750.00	8,932,250.00	83.24
2104	Хангамж, бараа материалын зардал	22,128,500.00	20,602,316.00	1,526,184.00	93.10
210401	Бичиг хэрэг	2,781,700.00	2,725,520.00	56,180.00	97.98
210402	Тээвэр, шатахуун	14,495,200.00	13,295,470.00	1,199,730.00	91.72
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,891,600.00	3,891,600.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	89,726.00	270,274.00	24.92
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	600,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,761,400.00	238,600.00	88.07
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,761,400.00	238,600.00	88.07
2107	Томилолт, зочны зардал	11,179,300.00	7,490,450.00	3,688,850.00	67.00
210702	Дотоод албан томилолт	9,179,300.00	5,491,000.00	3,688,300.00	59.82
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000,000.00	1,999,450.00	550.00	99.97
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,453,900.00	2,311,760.00	142,140.00	94.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,748,200.00	1,747,362.00	838.00	99.95
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,000.00	00.00	37,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	00.00	66,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	602,700.00	564,398.00	38,302.00	93.64
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21200000.00	21166300.00	33,700.00	99.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,200,000.00	21,166,300.00	33,700.00	99.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40879500.00	40297500.00	582,000.00	98.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,879,500.00	40,297,500.00	582,000.00	98.58
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,879,500.00	39,297,500.00	582,000.00	98.54
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	444,284,700.00	429,854,350.00	14,430,350.00	96.75
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	443,284,700.00	427,854,350.00	15,430,350.00	96.52
132001	Орон нутгийн төсвөөс	443,284,700.00	427,854,350.00	15,430,350.00	96.52
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	2,000,000.00	-1,000,000.00	200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	2,000,000.00	-1,000,000.00	200.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.00

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25.00	23.00	2.00	92.00
620001	Удирдах ажилтан	09.00	09.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	08.00	2.00	80.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	23.00	2.00	92.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	08.00	2.00	80.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06.00	06.00	0.00	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	09.00	09.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,906,000.00	24,717,133.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,906,000.00	24,717,133.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,906,000.00	24,717,133.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,486,092.00	23,271,427.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9486092.00	23,271,427.00
	Төвлөрүүлэлт	1419908.00	1,445,706.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		00.00
213208	Орон сууцны дэмжлэг үзүүлэх		00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,906,000.00	24,717,133.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,906,000.00	24,717,133.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,040,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,906,000.00	14,347,293.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		9,329,840.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын дарга Р.Болормаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 24-өөс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газар нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 104 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сумын нийгэм эдийг засгийн тогтвортой байдлыг хангах, төрийн нийгэм эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж хууль, ёсыг чандлан сахиулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 413114.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8262.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн

эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 546659.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10933.1 мянган төгрөгөөр тоцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2568971.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 262339.8 мянган төгрөгөөр буюу 10 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44929.4	89914.1	44984.7
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	18.2	28139.7	28121.5
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	44911.6	61774.4	16862.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2261701.4	2479057	217355.6
Үндсэн хөрөнгө	2664491.3	2985093.9	320602.6
Хуримтлагдсан элэгдэл	-68492.1	-104601.1	-36109
Нийт хөрөнгө	2306631.3	2568971.2	262339.9
Өр төлбөр	0	166.8	166.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2306631.3	2568804.3	262173
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2306631.3	2568971.2	262339.9

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Өмнөх онд авлага дансны үлдэгдэлгүй байсан ба харин тайлант онд авлагын данс 28139.7 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Засаг дарга асан Ц.Төмөрбаатар улс төрийн албан хаагч атлаа тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 2020 оны төсөвт суулган 2020.03.11-ны өдрийн төлбөрийн хүсэлтээр 39297.5 мянган төгрөгийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулал авсантай холбоотой авлага үүссэн байна.

Энэ нь Засаг дарга асан Ц.Төмөрбаатарын тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг улс төрийн албан хаагчаар биш төрийн албан хаагчийн тэтгэмж олгох журмын дагуу бодож 2020 оны төсөвт суулган 2020.03.11-ны өдрийн төлбөрийн хүсэлтээр 39297.5 мянган төгрөгийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшууллыг ажлаас гараагүй байхад олгож, илүү олгосон тэтгэмжийг тайланд авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна

Бараа материалын дансны үлдэгдэл 61774.4 мянган төгрөг болж 16862.8 мянган төгрөгөөр өссөн нь хандив тусламжаар 1150.0 мянган төгрөгийн шатах тослох материал, 595.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, ковид-19 цар тахалтай холбоотой Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 4482.9 мянган төгрөгийн өвлийн майхан, зөөврийн ширээ сандал, ор зэрэг хөрөнгийг бэлтгэн орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2985093.9 мянган төгрөг болж 320602.6 мянган төгрөгөөр өссөн нь Засаг даргын тамгын газрын 327826.1 мянган төгрөгийн байрыг орлогоор бүртгэж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 49 дүгээр тогтоолоор 13000.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь УТХО-оор хөрөнгө оруулалтаар хийгдсэн 327826.1 мянган төгрөгийн ЗДТГ-ын байр, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худлан авсан 5474.0 мянган төгрөгийн ухаалаг худгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2568804.3 мянган төгрөг болж 262173.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн 262173.0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 808832.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 911830.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээж авсан орлого 944744.7 мянган төгрөгөөр буурсан нь голлох нөлөөг үзүүлж байна. Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого өмнөх оноос 9329.8 мянга, туслах үйл ажиллагааны орлого 1367.0 мянган төгрөгөөр тус тус өссөн нь төсөвт байгууллагын орлого 10966.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, үнэ төлбөргүй хүлээж авсан орлого өмнөх оноос 944744.7 мянган төгрөгөөр буурсантай, тусламж санхүүжилтийн орлого 81558.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 67766.5 мянга, нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан санхүүжилт 13811.1 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

Нийт зардал 535013.5 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 106960.2 мянган төгрөгөөр буюу 20 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бараа, үйлчилгээний бусад зардал нэмэгдэж тайлант онд 11645.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдсаны гарз бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 265577.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 265577.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 109717.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 375294.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 375294.8 мянган төсөв батлагдаж 2020 оны 9-р сард тодотгол хийн 367876.8 мянган төгрөг болж 7418.8 мянган төгрөгөөр буурсан бол тайлант оны 12-р сарын байдлаар 444284.7 мянган төгрөгийн санхүүжилтээр, 1000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 427854.3 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 2000.0 мянга нийт 429854.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 429854.3 мянган төгрөгийг зарцуулж 14430.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 429854.3 мянган төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 1701.4 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1290.1 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 5277.3 мянга, хангамж бараа материалын зардлыг 1526.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 238.6 мянга, томилолт зочны зардлыг 3688.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 142.1 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 33.7 мянга, урсгал шилжүүлгийн зардлыг 582.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71801 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 11607.8 мянга, 81806 арга хэмжээ 2226.5 мянга, 80802 арга хэмжээ 582.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт.2 Төсвийн гүйцэтгэлийн тайлан /хөтөлбөр арга хэмжээгээр/

мянган.төг

№	ЭЗА	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
Хөтөлбөр-70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага						
НИЙТ			444,284.70	429,854.35	14,430.35	96.75
Арга хэмжээ 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал			308,997.30	297,389.72	11,607.58	96.24
1	210101	Үндсэн цалин	156,693.60	158,093.53	-1,399.93	100.9
2	210102	Нэмэгдэл	33,943.20	31,658.09	2,285.11	93.3
3	210201	Нийгмийн даатгалын шимтгэл	18,347.30	17,621.87	725.43	96.0
4	210202	Тэтгэмжийн даатгал	1,906.40	1,918.11	-11.71	100.6
5	210203	ҮОМШ-ний даатгал	1,525.10	1,268.97	256.13	83.2
6	210204	Ажилгүйдлийн даатгал	381.30	343.43	37.87	90.1
7	210205	Эрүүл мэндийн даатгал	3,812.70	3,679.26	133.44	96.5
8	210301	Гэрэл, цахилгаан	5,706.00	9,410.92	-3,704.92	164.9
9	210302	Түлш, халаалт	53,287.00	44,354.75	8,932.25	83.2
10	210401	Бичиг хэрэг	2,781.70	2,725.52	56.18	98.0
11	210402	Тээвэр, шатахуун	10,175.20	8,989.80	1,185.40	88.4
12	210403	Шуудан, холбоо, интернэт	3,891.60	3,891.60	0.00	100.0
13	210405	Хог хаягдал зайлуулах, хортон	360.00	89.73	270.27	24.9
1	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	600.00	600.00	0.00	100.0
2	210604	Урсгал засвар	2,000.00	1,761.40	238.60	88.1
3	210702	Дотоод албан томилолт	8,035.30	5,491.00	2,544.30	68.3
4	210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000.00	1,999.45	0.55	100.0
5	210801	Бусад нийтлэг АУТХураамж	1,748.20	1,747.36	0.84	100.0
6	210806	Мэдээлэл технолгийн үйлчилгээ	602.70	564.40	38.30	93.6
7	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200.00	1,180.52	19.48	98.4
Арга хэмжээ 80106 Баг, хорооны ҮАЗардал			75,407.90	73,181.35	2,226.55	97.0
1	210101	Үндсэн цалин	60,652.80	59,836.57	816.23	98.7
2	210201	Нийгмийн даатгалын шимтгэл	5,762.00	5,654.66	107.35	98.1
3	210202	Тэтгэмжийн даатгал	606.50	591.61	14.89	97.5
4	210203	ҮОМШ-ний даатгал	485.20	470.31	14.89	96.9
5	210204	Ажилгүйдлийн даатгал	121.30	113.01	8.29	93.2
6	210205	Эрүүл мэндийн даатгал	1,213.10	1,209.52	3.58	99.7
7	210402	Тээвэр, шатахуун	4,320.00	4,305.67	14.33	99.7
8	210702	Дотоод албан томилолт	1,144.00	0	1,144.00	0.0
9	210804	Тээврийн хэрэгслийн татвар	37.00	0	37.00	0.0
10	210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66.00	0	66.00	0.0
11	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000.00	1,000.00	0.00	100.0
Арга хэмжээ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,			40,879.50	40,297.50	582.00	98.6
1	213207	Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж	39,879.50	39,297.50	582.00	98.5
2	213209	Нэг удаагийн тэтгэмж, шаг урамшуулал	1,000.00	1,000.00	0.00	100.0
Арга хэмжээ 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө			19,000.00	18,985.78	14.22	99.93
1	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,000.00	18,985.78	14.22	99.9
Арга хэмжээ 82212 Хур хог хаягдал, орчны бохирдл			0	0	0	#DIV/0!
	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	0	0.00	#DIV/0!

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар төрийн өмчийг түрээслүүлсний орлого 9974.8 мянга, Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардал 847.2 мянга, ХАОСТ-н материал тушаасан зардал 30.0 мянга, төрийн албан хаагчийн орон сууцны дэмжлэг 10000.0 мянга, цахим тендерийн хураамж 105.0 мянга, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2019 оны үйл ажиллагааны шагнал 2000.0 мянга, усны картын үнэ Намжилаас 300.0 мянга, өвс тэжээлийн үнэ Намжилаас 300.0 мянга, ГХУСЗ-ын үнэ Намжилаас 1040.0 мянга нийт 24717.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж холбогдох зардалд зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл мэдээлбэл зохих 149 мэдээллээс Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) мэдээлэх мэдээллийг 8-р сард, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр) мэдээлэх мэдээллийг 1, 10-р сард мэдээлэл хугацаа хороож нийт 3 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Хүснэгт.3 Шилэн дансны мэдээлэл оруулсан байдал

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Хугацаа хоцроосон мэдээллийн талаар
1	Бүтэн жил	11	11	9		2	
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	3	36	36			
5	Тухай бүр	8	96	93		3	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) мэдээлэх мэдээллийг 8-р сард, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр) мэдээлэх мэдээллийг 1, 10-р сард мэдээлэл хугацаа хороож нийт 3 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн байна.
	Нийт	27	151	146		3	

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллагын өмнөх оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж аудит хийгдээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 44217.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 174.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 41500.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, 2543.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүллээ. /Хавсралт 1./

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 65890.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч 57600.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөв. Үүнд:

1. Тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд 2985093.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 61774.4 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгө байгаа нь тооллогын бүртгэл нярвын тайлангаар баталгаажиг байна. Харин тус байгууллын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 57600.0 мянган төгрөгийн үнэ бүхий дизель мотор биетээр байхгүй тооллогоор дутсан байна. Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 дүгээр захирамжаар тус дутагдсан хөрөнгийн эзэн холбогдогчийг тогтоож, хуулийн байгууллагаар шийдвэр гаргуулан байгууллагыг хохиролгүй болгох асуудлыг дарга, нягтлан бодогч нарт үүрэг болгосон ч захирамжийн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй тооллогоор дутсан хөрөнгүүдтэй холбоотой асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 8290.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант онд засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 2020.12.18-ны өдрийн А/141 тоот захирамжаар засаг даргын нөөц хөрөнгөнөөс 4040.0 мянган төгрөгийн 5 нэр төрөл бүхий хөрөнгө, сумын онцгой байдлын гишүүдэд 4250.0 мянган төгрөгийн дүрэмт хувцас нийт 8290.0 мянган төгрөгийг хөрөнгийг худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журамтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл: Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг мөрдөөгүйгээс төсвийг зориулалт бус зарцуулах.

1.3. Өгсөн зөвлөмж: Цаашид төсвийг зориулалтын дагуу хэмнэгдсэн зардлыг үр ашигтай зарцуулах “Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах” журмыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл санхүүгийн тайланд 197148.6 мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналд 197374.6 мянган төгрөгөөр буюу 226.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.44. “Дахин үнэлгээний нэмэгдлийг хэрэгжсэн үед нь хуримтлагдсан үр дүн данс руу шилжүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөөгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж: Аймгийн ОНӨГ-т хандан 2012, 2016 онуудад хийгдсэн дахин үнэлгээний тайлангийн мэдээллийн дагуу дахин үнэлгээ дансны бүртгэлийн зөрүүг залруулах арга хэмжээ авч ажиллах..

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Тус байгууллагын төсвийн төсөлд тусгаагүй боловч 2020 оны төсөвт тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 39297.5 мянган төгрөг батлагдсан бөгөөд Засгийн газрын 2019 оны 7-р тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг зөрчин мөн ажлаас чөлөөлөх тушаал шийдвэр гараагүй байхад сумын Засаг даргаар ажиллаж байсан Ц.Төмөрбаатарт тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжид 39297.5 мянган төгрөг олгож авлага үүсгэсэн байна.

3.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй хууль журам зөрчин зарцуулах.

3.3. Өгсөн зөвлөмж: Цаашид тэтгэвэрт гарч байгаа албан хаагчийн тэтгэмж тооцох цалингийн дунджийг зөв тооцох, холбогдох журмын дагуу бодож төсвийн төсөвт төлөвлөн оруулж байх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР

П.АМАРЖАРГАЛ 2021.02.25

Анхан шатанд хянасан:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЭНЯМ 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ 2021.02.25

5. Хавсралт 1: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо 2020	Аудитын нэр:	Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: БНА-2021/148/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газар	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Орон нутгийн өмчийн 2019 оны үзлэг тооллогоор дутагдсан 57600.0 мянган төгрөгийн хөрөнгийн эзэн холбогчийг тогтоож хуулийн байгууллагаар эцсийн шийдвэр гаргуулан байгууллагыг хохиролгүй болгох тухай Аймгийн Засаг даргын 2020 оны А/101 тоот захирамжийг төсвийн шууд захирагч хэрэгжүүлж ажиллаагүй байна.	57600.0	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	Р.Болормаа М.Мягмарсүрэн
2	Тайлант онд засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 2020.12.18-ны өдрийн А/141 тоот захирамжаар засаг даргын нөөц хөрөнгөнөөс 4040.0 мянган төгрөгийн 5 нэр төрөл бүхий хөрөнгө, сумын онцгой байдлын гишүүдэд 4250.0 мянган төгрөгийн дүрэмт хувцас нийт 8290.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	8290.0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Р.Болормаа М.Мягмарсүрэн
3	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл санхүүгийн тайланд 197148.6 мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн байхад ҮХ-ийн дэлгэрэнгүй журналд 197374.6 мянган төгрөгөөр буюу 226.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан байна.	-	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Р.Болормаа М.Мягмарсүрэн
4	Засгийн газрын 2019 оны 7-р тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг зөрчин мөн ажлаас чөлөөлөх тушаал шийдвэр гараагүй байхад сумын Засаг даргаар ажиллаж байсан иргэнд тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжид 39297.5 мянган төгрөг олгож авлага үүсгэсэн байна.	39297.5	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Р.Болормаа М.Мягмарсүрэн
ДҮН		105187.5			

оОо